



**“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

Огноо 2023.03.20

Дугаар 07

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан
Хуралдуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60.1, 62.1.1 болон 62.1.7 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Баянгол зочид буудал” ХК-ийн хувьцаа зэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04-р сарын 27-ны өдрийн 15 цагт Баянгол зочид буудал ХК-ийн рестораны Их танхимд хуралдуулахаар товлосугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай.Үүнд:
 - 2.1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг батлах;
 - 3.3. Ногдол ашиг хуваарилах талаар ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах.
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 4 сарын 7-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо МХБ-д хүргүүлэх өдрийг 2023 оны 03 дугаар сарын 21-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2022 оны 03 дугаар сарын 22; 2022 оны 4 дүгээр сарын 07-ны өдрүүд байхаар тогтоосугай.
5. Энэ тогтоолын 4-т заасан эхний өдөр буюу 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах, 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерийн компанийд хүргүүлэх, 2023 оны 03 дугаар сарын 22 болон 4 дүгээр сарын 07-ны өдрүүдэд өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио, телевизээр мэдээлэх зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
6. Дараах бичиг баримтг хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер дилерийн компаниуд дээр бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай.

6.1.Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрийн хуулбар;

6.2.Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд аудитын компаниас болон ТУЗ-өөс өгсөн дүгнэлт;

6.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийн төсөл;

6.4. Ногдол ашгийн талаар ТУЗ-ийн шийдвэрийн танилцуулга

6.5. Хурлын зар.

8. Хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү шийдвэрийн Хавсралт №1-ээр танилцах бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №2-оор тус тус баталсугай.

9. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2023 оны 4 дүгээр 27-ны өдрийн 15 цагаар тогтоосугай.

10. Саналын хуудсыг хүлээн авах, тоолох тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй сонгосугай. Үүнд:

Дарга: Д.Самданжамц

Гишүүд: Т.Дөлгөөн, Д.Цэцэгмаа, Т.Удвал

11. Хурал зохион байгуулах комиссын даргаар З.Цэрэнчимэгийг томилсугай.

12. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, төсөл, гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдэд танилцуулах ажлыг зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисс /З.Цэрэнчимэг/-д даалгасугай.



Б.АЮУШ